ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Л.МӨНХБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 41 52, Факс: (976-11) 32 66 11,
Цахим шуудан: info@namem.gov.mn

2025.07.18 № 01/452
танай 2025.06.30-ны № 1/172-т

Санал хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судлан үзээд дэмжих боломжгүй байх тул Цаг уур, орчны шинжилгээний салбартай холбоотой хэсгийн үндэслэл, тайлбарыг хүргүүлж байна.

1. Манай улсад цаг уурын өртөө 138, цаг уурын харуул 180, ус судлалын харуул /гол, нуур/ 155, аэрологийн өртөө 5 ажиллаж байна. Эдгээр нь **засаг захиргааны бүтэц дагасан бус** байгаль газарзүйн онцлог, дурын цэг дэх уур амьсгалын элементийн тоон утгыг орон зайд интерполяци хийхэд хангалттай байх, тухайн байршлын элемент нь өөр хоорондоо ялгаатай трендийг үзүүлж байх шаардлагын дагуу байгуулагдсан байдаг. Иймд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сүлжээний нэгж буюу аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв, өртөө, харуулыг байгуулах, татан буулгах, шилжүүлэх эрх нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.1-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын эрхэд хамаардаг.

2. Монгол Улс нь Дэлхийн Цаг Уурын Байгууллагын гишүүн орны хувьд нутаг дэвсгэртээ нэгдсэн ажиглалтын тогтолцоо бүрдүүлж, түүнийг тогтвортой ажиллуулах үүрэг хүлээдэг. Аймаг, нийслэл, төв суурин газрууд дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төв, өртөө, харуулууд нь ажиглалт, хэмжилтийн мэдээллийг нэгдсэн арга зүйгээр боловсруулж, олон улсын сүлжээнд тогтмол дамжуулах хариуцлагатай үүргийг аль ч түвшний **Засаг дарга, түүний Тамгын газрын оролцоогүйгээр** жилийн 365 хоногт 24 цагаар тасралтгүй гүйцэтгэдэг **төрийн үйлчилгээний мэргэжлийн алба** юм. Дэлхийн Цаг Уурын Байгууллага, Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагын шаардлага, олон улсын стандартыг хэрэгжүүлэх нь орон нутгийн бус улсын хэмжээний нэгдсэн бодлого, менежмент шаарддаг.

3. Аймаг, сумын цаг уур, орчны шинжилгээний мэдээ мэдээлэл нь тухайн аймаг дахь өртөө, харуулын станцын мэдээ, нийслэл хотод байрлах суперкомпьютерын тоон прогноз, хиймэл дагуулын газрын станцын мэдээ, олон улсын өгөгдлийн сүлжээ зэргээс бүрдэж боловсруулагддаг. Өөрөөр хэлбэл зөвхөн өндөр түвшний тоног төхөөрөмж, нарийн мэргэжлийн нэгдсэн арга зүй, өдөр тутмын төвлөрсөн удирдлагаар хийгддэг ажлууд тул Засаг дарга удирдлагыг томилбол мэргэжлийн бус хүмүүс удирдлагаар ажиллах, тухайлбал Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч төвийг удирдах, **улс төрийн нөлөөллөөр мэргэжлийн ажилтан,**

15225027
d:\2025\тоот\07.18-452.docx

албан хаагчдыг халах, солих эрсдэл бодитой болно. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилдог.

4. Цаг уурын мэдээлэл бол **үндэсний аюулгүй байдал, иргэдийн амь нас, эд хөрөнгийн хамгаалалттай шууд холбоотой** стратегийн өгөгдөл тул нүүдлийн мал аж ахуйтай манай орны хувьд онцгой чухал ач холбогдолтой төрийн суурь үйлчилгээ болох цаг уур, орчны шинжилгээний салбарыг 101 жилийн турш бүтцийн аливаа өөрчлөлтгүйгээр олон улсын жишгийн дагуу ажиллуулж ирсэн. **Дэлхийн бүх улсад цаг уурын төвүүд төвлөрсөн, мэргэжлийн удирдлагатай**, олон түвшний баталгаажуулалттай байдаг.

5. Холбооны сүлжээ, хиймэл дагуул, цаг уурын радар, автомат станц зэрэг дэд бүтцүүд нь **төвлөрсөн хөрөнгө оруулалт, хамтын сүлжээний зохион байгуулалт** шаарддаг. Орон нутгийн төсвөөр эдгээрийг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал. Орон нутгаас удирдлага нь томилогдох тохиолдолд төсвийн хүндрэл үүсэж, хариуцлагын тогтолцоо алдагдах эрсдэлтэй. Учир нь Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд нь цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрөөс санхүүждэг бөгөөд Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга нь **төсвийн төвлөрүүлэн захирагчийн** хувьд Төсвийн тухай хуулиар тогтоосон эрх үүргийг хэрэгжүүлдэг.

6. Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүд нь байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээний улсын сүлжээний үүргийг гүйцэтгэдэг бөгөөд байгаль орчинд гарах физик, хими, биологийн хувьсал өөрчлөлт, бохирдолтын түвшинд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа хийж байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг тогтоох, үнэлгээ өгөх ажлыг гүйцэтгэдэг тул аймаг, нийслэлийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд байгалийн нөөцийг ашиглах, ашиглуулах үйл ажиллагаанд **хараат бус хяналт-шинжилгээ хийх тогтолцоо алдагдаж**, Байгаль орчныг хамгаалах тухай хууль /10 дугаар зүйл. Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээ/ зөрчигдөхөөр байна.

Хүндэтгэсэн,
ДАРГА Э.БАТТУЛГА